



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/216

Мандалговь

“Аймгийн ИТХ-ын ажлын албаны
хэрэгцээт тоног төхөөрөмж нийлүүлэх”
тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн ИТХ-ын ажлын албаны хэрэгцээт тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Э.Мөнхзол (Иргэний төлөөлөл)

Т.Мөнхбаяр (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч)

Б.Пэрэнлэймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



489211061